



**НИЙСЛЭЛИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

“Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн  
тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/220 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.

2.Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 92,456,000 (ерэн хоёр сая дөрвөн зуун тавин зургаан мянган) төгрөгийг “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ”-ний зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1109 дүгээр тушаалын хавсралт



“Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/	
1.	Тамирчдын шагнал	1-р байр	78 хүн	30,000	2,340,000
		2-р байр	78 хүн	20,000	1,560,000
		3-р байр	78 хүн	10,000	780,000
2.	Багийн шагнал	1-р байр	6	200,000	1,200,000
		2-р байр	6	150,000	900,000
		3-р байр	6	100,000	600,000
3.	Шилдэг сургууль	1	1,000,000	1,000,000	
4.	Шүүгчдийн зардал	17 x 5 өдөр	120,000	10,200,000	
5.	Заал талбайн зардал	1 x 5 өдөр	10,000,000	50,000,000	
6.	Тээвэр, шатахуун	-	-	300,000	
7.	Шторк	40сек	-	2,500,000	
8.	Спорт, урлагийн тоглолт	-	1,500,000	1,500,000	
9.	Хөтлөгч	2 өдөр	500,000	1,000,000	
10.	Үзель, хөгжим	10 нүүр	200,000	2,000,000	
11.	Тайз, чимэглэл, карказ	10x4x3	-	3,000,000	
12.	Өргөмжлөл батламж (цаасан)	408ш	2,000	816,000	
13.	Урилга	20ш	5,000	100,000	
14.	Өргөмжлөл (модон)	20ш	100,000	2,000,000	
15.	Медаль	240ш	20,000	4,800,000	
16.	Хулдаасан хэвлэл	155м2	12,000	1,860,000	
17.	Цом	32ш	100,000	3,200,000	
18.	Зохион байгуулагч, шүүгчдийн хоол, цай кофе, ус, ундааны зардал	20 хүн x 5 өдөр	-	800,000	
<b>ДҮН</b>					<b>92,456,000</b>